




Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР




2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, 2021 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ДАРГА Б.БААСАНЖАРГАЛ
2021-02-19


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны Худалдан авах ажиллагааны нэгтгэл тайланд 82 байгууллагын **42.1 тэрбум** төгрөгийн төсөвт өртөгтэй, **1172** төсөл арга хэмжээг худалдан авалтыг тайлагнаж хуулийн хугацаанд буюу 2021.01.14-нд Сангийн яаманд хүргүүлж ажилласан.




ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ ХЭРЭГЛЭСЭН БАЙДЛААР НЬ:



Орон нутгийн өмчийн газрын 2020 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан **33.2 тэрбум** төгрөгийн төсөвт өртөгтэй, 72 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг давхардсан тоогоор 107 тендер зарлаж, 100 хувийн гүйцэтгэлтэй, **916.4 сая** төгрөгийн хэмнэлт, үр ашигтай, ил тод, хариуцлагатай зохион байгуулсан.



Хөрөнгө оруулалтын чиглэлээр нь авч үзвэл:



ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

№	Гомдол хүлээн авагч	Гомдол гаргагч байгууллага	Тендер шалгаруулалтын нэр	Шийдвэрлэсэн байдал
1	Сангийн яам, Хууль Эрх зүйн газар	Кенжикү ХХК	Цэцэрлэгийн барилга, 100 ор, Дархан сум, Өргөө баг /төсөвт өртөг 1,100.0 сая төгрөг/	Дахин зарлагдсан

Шалгарсан гүйцэтгэгчдийг харъяаллаар нь:

■ Төсөл, арга хэмжээ /тоо/

■ Гэрээ байгуулагдсан дүн /сая.төг/

Дархан **42**

18,520.1

Улаанбаатар
болон бусад **30**

13,727.2

**ШАЛГАРСАН ОРОН НУТГИЙН
КОМПАНИ**

58 %

Мэдээллийн ил тод байдал

2020 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 82 байгууллагууд болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтыг 100 хувь цахимаар зохион байгуулах чиглэл өгч, хэрэгжилтийг хангаж ажилласнаар давхардсан тоогоор **284** төсөл арга хэмжээг цахимаар зохион байгуулсан.


Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим систем, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны www.darkhan.gov.mn цахим хуудас, газрын ил тод мэдээллийн самбарт худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үрд дүнг тухай бүр нийтлэж, үндэсний хэмжээний өдөр тутмын “Өдрийн сонин”, “Монголын Үнэн”, “Өглөөний сонин”-ий газруудтай гэрээ хийж хамтран ажилласан.

Шилэн www.shilendans.gov.mn дансанд худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, худалдан авалтын талаарх ерөнхий мэдээллийг тухай бүр байршуулж ажилласан.


Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгж боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтлах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлэхгүй байхад анхаарч, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс давхардсан тоогоор 140 гаруй иргэдийг Үнэлгээний хороонд оролцуулж, хөндлөнгийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналтаар оролцсон иргэд, төрийн бус байгууллагын 48 иргэнд **2,319.0** төгрөгийн урамшуулал олгож ажилласан.

2021 ОНЫ ХУДАЛДАН АВАЛТ


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 82 байгууллагын 18.4 тэрбум төгрөгийн 1022 төсөл арга хэмжээ нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж, Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд ил тод, нээлттэй мэдээлсэн.




Орон нутгийн өмчийн газрын 2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 6.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.




ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ:




САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ;



ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦ 38%



Монгол Улсын Засгийн газрын 2021.01.20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 14.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээ эрх шилжигдэн ирэхээр хүлээгдэж байна. 2021.02.19-ний өдрийн байдлаар ЗГХЭГ, БШУЯ-наас эрх шилжин ирсэн байна.



Үнэлгээний хороо


Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн суурь мэдлэг олгох сургалтыг төрийн бус байгууллагатай хамтран 2020 онд 2 удаа зохион байгуулж 62 хүн хамруулж, 36 хүн тэнцсэн.

2021 онд цахимаар 1 удаагийн сургалт зохион байгуулж, 54 хүн хамруулж, 26 хүн тэнцсэн.

Одоогийн байдлаар Үнэлгээний хороонд ажиллах эрх бүхий АЗ сертификат эзэмшигч 116 хүн байна. Үүнд:

- Удирдах албан хаагч-14
- Төрийн албан хаагч-53
- Хувийн хэвшил, иргэд, ТББ-49

Үнэлгээний хороонд ажиллах эрх бүхий АЗ сертификат эзэмшигч 116 хүн бүртгэлтэй байна. Ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл:



■ Удирдах албан тушаалтан

■ Төрийн албан хаагч

■ Хувийн хэвшил, иргэд, ТББ

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**